



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/524

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх зорилт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 31 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Алтай сумд 1,735,920 (нэг сая долоон зуун гучин таван мянга есөн зуун хорь) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 1,735,920 (нэг сая долоон зуун гучин таван мянга есөн зуун хорь) төгрөгийн зардлыг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Үйл ажиллагаа зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнахыг ажлын хэсэг (Д.Батбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР